

Ральф Хотцы: Германд цэврээрээ үлдсэн ганцхан га газар бий



ХБНГУ-ын иргэн, байгаль хамгааллын чиглэлийн ажилтан, ноён Х.Ральфтай ярилцлаа.

-Эрхэм Ральф та ямар ажлаар Монголд ирээ вэ?

-Би анх удаа бус 12 дахь жилдээ ирж байна даа. Харин энэ удаад дэлхийд цор ганцхан газар үлдээд буй говийн мазаалай баавгайг хэрхэн хамгаалах боломжийг судлах томилолт авсан.

-Та өөрийнхөө ажил мэргэжлээ танилцуулахгүй юу?

-Германы Баваар мужид төвтэй "LBV" хэмээх байгаль хамгаалах чиглэлийн төрийн бус байгууллагад ажилладаг. Манай байгууллага байгуулагдсаныхаа 100 жилийн ойг удахгүй тэмдэглэнэ. Тэгэхээр их буурал түүхтэй ТББ гэж болно. Өөрөөр хэлбэл зуун жилийн турш төв Европын нутаг дахь Альпийн нурууг хамгаалах үйлсэд зүтгэж яваа байгууллага. Энэ хооронд дэлхийн хоёр том дайн болоод өнгөрч. Манай ажлыг идэвхтэй дэмждэг 70000 гишүүн бий.

-LBV одоо юу хийж байна?

-Байгаль хамгаалах боловсролыг иргэдэд олгох, улаан дансанд орсон амьтдыг хамгаалах [улаан ном. орч], мэдээж Альпийн нурууны гол горхи, амьтан ургамалд санаа тавих зэрэг үндсэн ажилтай. Германд ТББ нь төрийн байгууллагаас илүү нэр хүнд итгэлийг хүлээдэг болохоор ажил үйлс дандаа бүтэмжтэй байдаг.

-Европт хамгаалаад байхаар тийм сул эзгүй газар бас байхнээ?

-Эзэнгүй газар байхгүй. Хамгаалах шаардлагатай газар бол бий. Тийм тохиолдолд эзэнтэй нь ярьдаг юм. Тэгээд нэг бол газрыг нь үнэ тохирч авна. Энэ хэцүү. Сонирхуулахад Альпийн нуруунд яг цэвэр онгоноороо үлдсэн ганцхан га газар байдаг. Бид тэндээ янз бүрийн судалгааны ажил хийдэг.

-Таны хувьд тэнд юу хийх вэ?

-Миний мэргэжил ургамал судлаач тул хийх ажил ихтэй. Энэ ажилд орсноор асар уудам цэвэр онгон байгалийг үзэх юмсан гэж мөрөөддөг байлаа. Тэгээд санамсаргүй тохиолдлоор танай МУИС-ийн багш, доктор Самъяатай танилцсанаар миний хүсэл биелсэн юм.

-Мазаалайн тухай ярьсан яриагаа цааш үргэлжлүүлэхгүй юу?

-Сая би Алтайн цаадах говь орж Сэгс цагаан Богд ууланд хэд хонолоо. Хамт яваа нөхөд дурангаар энэ амьтныг харсан. Мазаалай гэдэг амьтан байгаа нь үнэн юм байна. Нутагтаа очоод хандив цуглуулж энэ амьтныг хамгаалах үйлсэд зориулахаар төлөвлөж байна. Юуны өмнө Эхийн гол дээр судалгааны төв байгуулах шаардлагатай байх.

-Европчууд тахийг устахаас аварсан. Одоо мазаалайн хэдэн бамбарууш бариад буцах бодол танд байгаа юу?

-Энэ бол амьтныг хамгаалах хамгийн муу арга. Зоопарк бол эцсийн хувилбар. Амьтан хамгаалах, устахаас сэргийлэх олон хувилбар байгаль орчны салбарт нээгдээд байна.

-Баавгай хамгаалах үйлс тань бүтнэ гэдэгт та итгэлтэй байна уу?

-Найдаж байгаа. Аливаа байгаль хамгаалах ажилд төрийн оролцоо хамгийн найдваргүй байдаг. Олон нийтийн, болон орон нутгийнхантай энэ ажлыг хийдэг жишиг тогтсон. Бид Монгол дахь мэргэжлийн хүмүүстэй, мөн байгаль хамгаалах ТББ-тай хамтарч ажиллах байх. Тэд энэ ажлыг өөрсдөө хийж бид санхүүжүүлнэ.

-Эндэхийн мазаалайг хамгаалах нь тэндэхийн Баваар мужид ямар учир нөлөөтэй байна вэ?

-Энэ бол манай байгууллагын хувьд нэр төрийн хэрэг юм. Олон улсын байгаль хамгааллын бусад байгууллагуудтай хамтын ажиллагаатай байдаг. Тэгээд ч мазаалай бол ганц Эхийн голын өмч биш хүн төрөлхтний өмч. Бидний үед байгаа устах аюулд орсон олон амьтан байна. Үүний нэгдүгээрт мазаалай юм гэдгийг дэлхий нийтэд таниулах, дуулиан тарих хэрэгтэй. Тэгж байж хулсны панда баавгай шиг энэ амьтан аврагдана.

-Мазаалайг хамгаална гэхээр агнахгүй, үргээхгүй төдий ажил биш байх?

-Тийм. Говийн экосистемийг бүхлээр нь хамгаалах тухай асуудал юм. Юун түрүүн уул уурхай нээгдэх вий гэхээс түгшиж байна. Уурхай бол агшин зуурын ашиг тус. Гэтэл байгальд судлагдаагүй маш олон бодьгал байна. Ургамал гэхэд л 300 мянган төрөл зүйлээс дөнгөж 20 хувийг нь одоо л хагас дутуу таньж байна. Саяхан Африкийн нэг орноос хорт хавдрын эсрэг бэлдмэлийг санамсаргүй ургамлаас илрүүлээ. Танай говьд алтнаас илүү үнэд хүрэх ямар ургамал хөрс байгааг төгс судалж мэдээгүй байгаа. Хаана байгаль эрүүл гэдгийн итгэлцүүр энэ амьтан амьдарч байгаагаар нотлогдоно.

-Монголд ирэх их дуртай юмаа даа?

-Тийм шүү. Монгол нь Азийн бусад орныг бодвол илүү европжсон, хүмүүс нь их нээлттэй илэн далангүй байдагт нь таалагддаг. Гэхдээ Азийн бусад орон хийгээд манай европынхон дэлхийн II дайнаас хойш нэгэндээ итгэхээ больсон, хувиа хичээсэн зантай болсон. Найз нөхөр гэдэг ойлголтыг би Монголоос л авч байна.

-Хоол тохирохгүй, ус таарахгүйн нэг зовлон бий биз?

-Харин ч эсрэгээр гээч. Баваартаа очоод "гүйлгээд" эхэлдэг.

-Та анд хэр зэрэг вэ? Сайн буу бий юу?

-Надад гайгүй сайн зургийн аппарат бий. Түүгээрээ л "ан" хийдэг дээ. Хэдийбээр ургамал судлаач мэргэжилтэй ч байгалийн ургаж буй өвс ургамлыг бараг тасдаж үзээгүй юм байна.

-Сонирхолтой яриа өрнүүлсэнд баярлалаа. Ажилд тань амжилт хүсье. Та аян замдаа сайн яваарай.

-Баярлалаа